

САНГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 12 дугаар сарын 26 өдөр

Дугаар 289/А/345

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, танхимын бус сургалтын багц цагт хамаарах ажлын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/-т, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж, зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газар /А.Хишигбаяр/-т, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн захирлуудад тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/198/215 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШИЙН СУРГАЛТЫН АЖЛЫГ БАГЦ ЦАГААР ТООЦОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн ба төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын багш, тэнхимийн эрхлэгч, сургалтын албаны дарга /менежер/, сургалт хариуцсан арга зүйч /цаашид багш гэх/ -ийн сургалтын ажлыг багц цагаар тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2 Багшийн ажил нь Боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан багшийн үүргийн хүрээнд багшийн ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлогдох бөгөөд багц цаг нь сургалтын цагийн жилийн ачаалал, цалин, нэмэгдэл хөлс тооцох үндэслэл болно.
- 1.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын төлөвлөгөө, норм, норматив, батлагдсан орон тооны хязгаарт үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах багшийн орон тоог Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн захирал тогтооно.
- 1.4 Багц цаг нь багшийн ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын зэрэглэл ба ур чадварын түвшин, ажлын үнэлгээтэй харилцан уялдаатай байна.
- 1.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хичээлийн нэг цаг /цаашид "цаг" гэх/-ийн хэмжээ нь 40 минут байх бөгөөд хоёр цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 80 минутад багтаан явуулахаар сургуулийн хичээлийн хуваарьт тусгана.
- 1.6 Сургууль дээрх дадлагын сургалтын нэг ээлжид хичээллэх суралцагчдын тоо 15-аас ихгүй байна.
- 1.7 Үндсэн цалин ба нэг багц цагийн үнэлгээ харилцан хамааралгүй байна.
- 1.8 Мэргэжлийн онолын болон дадлагын, ерөнхий эрдмийн багшийн жилийн сургалтын цагийн ачаалал нь 20 багц байна.

### Хоёр. Багшийн сургалтын ажлын ачааллыг тогтоох, тооцох

- 2.1 Багшийн сургалтын цаг нь танхимын ба танхимын бус багц цагаас бүрдэнэ.
- 2.2 Танхимын сургалтын багц цагт онол /лекц, семинар/, лаборатори, сургууль дээрх дадлага, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагыг хамруулна.
- 2.3 Танхимын бус сургалтын багц цагт сургалтын үйл ажиллагааг дэмжих, багшийн хөгжлийг хангах, иргэд, түншлэгч байгууллагуудтай харилцах, суралцагчийг төлөвшүүлж, хөгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаануудыг хамруулж тооцно.
- 2.4 Багшийн жилийн сургалтын цагийн ачааллаас давуулан гүйцэтгэж байгаа танхимын ба танхимын бус багц цаг нь нэмэгдэл хөлс болж тооцогдоно.
- 2.5 Нэг багц цагийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 60 хувиас

доошгүй байна.

- 2.6 Сургалтын албаны дарга/менежер/, арга зүйч зайлшгүй шаардлагын улмаас хичээл заасан тохиолдолд нийт заах багц цагийн хэмжээ хагас жилд 4 багц цаг буюу жилд 8 багц цагаас хэтрэхгүй байна.

### **Гурав. Танхимын сургалтын багц цагийг тооцох**

- 3.1 Онол, лаборатори, сургууль дээрх дадлагын 36 цагийн бодит гүйцэтгэлийг, үйлдвэрлэлийн ба төгсөлтийн өмнөх дадлагын 72 цагийн бодит гүйцэтгэлийг, танхимын бус сургалтын 72 цагийн бодит гүйцэтгэлийг тус тус нэг багц цаг гэж тооцно.
- 3.2 Багшийн сургалтын ажлын ачааллыг тооцож үнэлэхдээ танхимын болон танхимын бус сургалтын багц цагийг хооронд нь шилжүүлж тооцохгүй.
- 3.3 Багш албан тушаалтан тэнхимийн эрхлэгчийн албан үүргийг хавсран гүйцэтгэсэн тохиолдолд жилд гүйцэтгэх /танхимын ба танхимын бус/ багц цагийн ачааллыг 40 хүртэлх хувиар хорогдуулж тооцно.

### **Дөрөв. Танхимын бус сургалтын багц цагийг тооцох**

- 4.1 Танхимын бус сургалтын багц цаг нь багшийн албан тушаалын зэрэглэлээс хамаарч, жилийн сургалтын цагийн ачааллын 20 хүртэл хувь байх ба бодит баримтад үндэслэн тооцно.
- 4.2 Танхимын бус сургалтын багц цагт хамаарах ажлын жагсаалтад заасан ажлуудын гүйцэтгэлийг сар, хагас жил, жилээр тооцно.

### **Тав. Бусад**

- 5.1 Мэргэжлийн болон техникийн, бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтын комиссын гишүүний цагийн гүйцэтгэл нь 50 цагаас ихгүй байх бөгөөд нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас ихгүй байна.
- 5.2 Танхимын ба танхимын бус сургалтын багц цагийн бодит гүйцэтгэлийг холбогдох албан тушаалтнууд тооцон, сургалтын албаны дарга/менежер/ хянаж, нийт тооцоог санхүүгийн албанд өгнө.
- 5.3 Багш нь танхимын ба танхимын бус сургалтын багц цагийн илүүг сар, хагас жил, хичээлийн жилийн эцэст тооцуулж болно.
- 5.4 Үндсэн багшийн оронд тодорхой шалтгааны улмаас нөхөн, орлон заасан бол холбогдох багц цагийн хөлсийг нэг багц цагийн үнэлгээний 70 хувиас ихгүй байхаар тооцож олгоно.
- 5.5 Гадны багш, инженер, техникийн ажилтныг цагаар ажиллуулсан тохиолдолд сургалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, нэг цагийн хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4 хувиас ихгүй хэмжээгээр тооцож олгоно.
- 5.6 Танхимын ба танхимын бус сургалтын ажлын ногдол багц цагийг хүндэтгэх бус шалтгааны улмаас биелүүлээгүй нөхцөлд дутуу гүйцэтгэсэн багц цагийн хөлсийг тухайн багц цагт харгалзах хэмжээгээр багшийн цалин хөлснөөс хасаж тооцно.

Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
 2019 оны 11 дугаар сарын 26 ний  
 өдрийн 134/ дугаар хамтарсан тушаалын  
 хоёрдугаар хавсралт

**ТАНХИМЫН БУС СУРГАЛТЫН БАГЦ ЦАГТ ХАМААРАХ АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	Ажил үйлчилгээ	Тооцох багц цаг	Тооцох хугацаа	Танхимын бус сургалтын багц цаг тооцох эрх бүхий тушаалтан
1	Сургуулийн сургалт аргазүй, мэргэжлийн болон сургалт-үйлдвэрлэлийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн, салбарын тэргүүлэх эрдэмтдийн тодорхойлолт, шүүмж авсан ном сурах бичиг бичиж хэвлүүлсэн, хамтран бичсэн бол	Үндэсний хэмжээний сурах бичиг бичсэн бол – 2,0 багц цаг Багт ажилласан бол – 1,0 багц цаг	Тухай бүрт	Сургалтын албаны менежер
2	Гарын авлага бичиж хэвлүүлсэн, хамтран бичсэн бол	0,7 багц цаг Хамтарсан бол – 0,3 багц цаг	Тухай бүрт	Сургалтын албаны менежер
3	Ном, сурах бичиг редакторласан бол	0,2 багц цаг	Тухай бүрт	Сургалтын албаны менежер
4	Зөвлөмж, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж, нийтлүүлсэн /гадаад дотоодын сонин, сэтгүүл эрдэм шинжилгээний бичигт/ бол	Дотоодод – 0,5 багц цаг Гадаадад – 0,7 багц цаг	Тухай бүрт	Сургалтын албаны менежер

		цаг		
5	Техникийн болон Мэргэжлийн боловсролын сургалтын төлөвлөгөө боловсруулсан (багт)	Шинээр – 0,5 багц цаг Шинэчилж – 0,3 багц цаг	Тухай бүрт	Сургалтын албаны менежер
6	Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах багт ажилласан бол	1,0 багц цаг	Тухай бүрт	Сургалтын албаны менежер
7	ЧСС-ын хөтөлбөр, Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулж баталгаажуулсан бол	Мэргэжлээр (багт)– 1,0 багц цаг Нэгж – 0,1 багц цаг	Тухай бүрт	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
8	Цөм хөтөлбөрт нийцүүлэн Бүрэн дунд боловсролын хичээлийн иж бүрэн хөтөлбөр боловсруулсан /нэг хичээлд / бол	0,2 багц цаг	Тухай бүрт	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
9	Сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт /зурагт болон биет үзүүлэн, слайд, аудио ба видео бичлэг/	Бүлэг сэдвээр /элемент/ – 0,4 багц цаг	Хагас жилд	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
10	Олимпиад мэргэжлийн уралдаанд багш өөрөө болон суралцагч амжилт гаргасан бол	Олон улсад байр эзэлсэн бол -2 багц цаг: Оролцсон бол -0,2 багц цаг: Улс : I байр – 1,5 багц цаг II байр – 1,0 багц цаг III байр – 0,8 багц цаг Бүс /хот, аймаг, дүүрэг/ :	Тухай бүрт	Сургалтын албаны менежер

		<p>I байр – 0,8 багц цаг</p> <p>II байр – 0,6 багц цаг</p> <p>III байр – 0,4 багц цаг</p> <p>Улс бүсийн тэмцээнд тусгай байр эзэлсэн бол: 0,2 багц цаг</p> <p>Улс бүсийн тэмцээнд оролцсон бол: 0,1 багц цаг</p> <p>Сургууль:</p> <p>I байр – 0,3 багц цаг</p> <p>II байр – 0,2 багц цаг</p> <p>III байр – 0,1 багц цаг</p>		
11	Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хуралд илтгэл тавьж амжилттай оролцсон бол	<p>Улс : I байр – 1,0 багц цаг</p> <p>II байр – 0,8 багц цаг</p> <p>III байр – 0,6 багц цаг</p> <p>Бүс /хот, аймаг, дүүрэг/ :</p> <p>I байр – 0,5 багц цаг</p> <p>II байр – 0,4 багц цаг</p> <p>III байр – 0,3 багц цаг</p> <p>Улс бүсийн тэмцээнд тусгай байр эзэлсэн бол: 0,2 багц цаг</p> <p>Улс бүсийн тэмцээнд оролцсон бол: 0,1 кр</p> <p>Сургууль:</p>	Тухай бүр	Сургалтын албаны менежер

		I байр – 0,3 багц цаг II байр – 0,2 багц цаг III байр – 0,1 багц цаг Сургуульд оролцсон бол: 0.05 багц цаг		
12	Багш сургуулийн болон сургалтын үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээний ажилд оролцож, патент авсан бол	1,0 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
13	Тухайн жилд докторын зэрэг хамгаалсан бол	Бүтээлийн чөлөө аваагүй бол – 2,0 багц цаг Бүтээлийн чөлөө авсан бол 0,5 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
14	Лаборатори, дадлагын газар, кабинет байгуулсан бол	Шинээр – 1,0 багц цаг Шинэчилсэн – 0,3 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
15	Дадлагын газрын хөдөлмөрийн, аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажилласан бол	0.05 багц цаг	Сар бүр	ХАБЭА хариуцсан ажилтан
16	Дадлагын газар лаборатори, кабинет хариуцсан байдал	0.2 багц цаг	Сар бүр	Аж ахуй хариуцсан ажилтан
17	Жижүүр багшийн үүргийг хангалттай сайн гүйцэтгэсэн байдал	0.05 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч

18	Анги хамт олноо сурлага хүмүүжлийн зөрчилгүй хариуцаж ажилласан байдал	0.2 багц цаг	Сар бүр	Нийгмийн ажилтан
19	Сургалтын орчин бүрдүүлсэн байдал /ангийн эд хогшлын бүрэн бүтэн байдал, ангийн тохижилт/	0.1 багц цаг	Сар бүр	Аж ахуй хариуцсан ажилтан
20	Сургууль, суралцагчийн зөвлөл, хамт олноос зохиосон ажил, тэмцээн уралдаанд, анги хамт олноо удирдаж шагналт байрт шалгарсан	0,03 багц цаг	Тухай бүр	Нийгмийн ажилтан
21	Бусад байгууллагаас зохион байгуулсан уралдаан тэмцээнд багш /бэлтгэсэн суралцагч/ шагналт байранд орсон байдал /СА - аас зөвшөөрөгдсөн/	0,1 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
22	СА-ны зөвшөөрлөөр дугуйлан, секц, сонгон удирдаж амжилттай зохион байгуулсан байдал	1,0 багц цаг	Хагас жилд	Сургалтын албаны менежер
23	Сургуулийн нэр дээр төсөл боловсруулж хэрэгжүүлсэн бол	1,0 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
24	Хөндлөнгийн шалгалтаар сурлагын чанар ахиц гарсан байдал	0,3 багц цаг	Хагас жилд	Сургалтын албаны менежер
25	Бичиг баримт, мэдээ судалгаа, бүртгэл хөтлөлт	0,06 багц цаг	Сар бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
26	Сургуулийн захиргаанаас өгсөн ажил үйлчилгээ, үүрэг даалгаврыг амжилттай	1,0 багц цаг хүртэл	Тухай бүр	Сургалтын албаны менежер

	сайн гүйцэтгэсэн /үүрэг даалгаврын хуудсыг үндэслэн/ бол			
27	Суралцагчид, багш, хамт олны дунд семинар, сургалт, уралдаан зохион байгуулж санаачлагатай ажилласан /СА – аар зөвшөөрөгдсөн/ бол	0,1 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
28	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажилласан бол	0,1 багц цаг	Хагас жилд	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
29	Багш нь суралцагчаа гарааны бизнес эрхлүүлсэн, суралцагчаа хөгжүүлэх замаар шинэ санаа, бүтээл хамтран гаргасан	0,3 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
30	Багш нь онлайн сургалт зохион байгуулсан	0,2 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
31	Багш нь үндсэн мэргэжлээрээ бие даан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн бол /Сургуулийн болон төсөл хөтөлбөрийн зохион байгуулалттай, яам, түүний харьяа байгууллагын төлөвлөсөн сургалт хамаарахгүй/	Баримтыг үндэслэн - 0,4 багц цаг	Тухай бүр	Сургалтын албаны менежер
32	Багш нь төгсөгчдийг ажлын байраар хангасан бол	Нэг ажлын байр нь 0,01 багц цаг	Тухай бүр	Нийгмийн түншлэл хариуцсан ажилтан
33	Ажил үйлчилгээ гүйцэтгэж сургуульд оруулсан ашгийн 600,000 төгрөг тутамд	1,0 багц цаг	Тухай бүр	Нягтлан бодогч
34	Багш, суралцагчийн хяналтын графикийг /давтлага, зөвлөгөө өгөх, бие даалт тооцох, явцын шалгалт авах/ тогтмол мөрдөж	0,1 багц цаг	Хагас жилд	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч

	ажилласан байдал			
35	Вэб –д суурилсан хичээлийн иж бүрэн электрон хавтас бүрдүүлж, сургалтанд ашигласан /нэг хичээлд/ бол	0,5 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
36	Багийг ахлаж амжилттай ажилласан /сар, жилийн ажлын төлөвлөгөө, ажлын үр дүнг харгалзан/ бол	0,1 багц цаг	Сар бүр	Сургалтын албаны менежер
37	Бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтад бэлтгэх давтлага өгсөн	1 ангид – 0.1 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
38	Курсын болон график тооцооны ажил удирдсан бол	1 суралцагчид 0.03 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
39	Дипломын төсөл удирдсан бол	1 сурагчид -0,15 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
40	Мэргэжлийн зэрэг тогтоох шалгалт	1 мэргэжилд – 0.1 багц цаг	Тухай бүр	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч